



**ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 23

Бор-Өндөр

**ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх хэсэг, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Бор-Өндөр суманд 2017 онд төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээнд олгогдсон газрын зориулалтыг өөрчлөн орон сууцны зориулалттай болгож төрийн байгууллагын зайлшгүй хэрэгцээ болон иргэдийн орон сууцны хэрэгцээг хангаж ажиллахыг Засаг дарга П.Чинбатад үүрэг болгосугай.
2. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, үйлдвэрлэл, дэд бүтцийн хороон дарга Э.Эрдэнэбатад даалгасугай.

ДАРГА  Д.ОТГОНЦЭЦЭГ

